

Өгөгдөл хамгаалах тухай хууль

Эстони Улс

2003 оны 3 дугаар сарын 12

Нэгдүгээр хэсэг

Ерөнхий нөхцөл

1. Хуулийн зорилт

Энэхүү хуулийн зорилт нь олон нийтийн ашиг сонирхолын дагуу Хувийн өгөгдөл мэдээлэлд хандахдаа тухайн хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэн үзэж хамгаалахад оршино.

2. Хуулийн хамрах хүрээ

(1) Энэхүү хууль нь доорх хууль тогтоомжуудын бусад актаас бүрдэнэ:

- 1) Хувийн өгөгдөл мэдээлэлийг боловсруулах нөхцөл, журам
- 2) Хувийн өгөгдөл мэдээлэлийн боловсруулалтанд улсаас тавих хяналтыг мөрдөх журам
- 3) Хувийн өгөгдөл мэдээлэлийн боловсруулалтын хууль бус хандалтанд хүлээлгэх хариуцлага

(2) Дараах зүйлс энэ хуулийн хүрээнд хамаарахгүй:

- 1) Хувь хүн хувийн зорилгоор хувийн өгөгдөл мэдээлэлд хандах
- 2) Хууль ёсны дагуу олон нийтийн хэрэглээнд зориулж хувийн өгөгдөл мэдээлэлд хандах
- 3) Өөр бусад аргаар Эстонийн өгөгдөл мэдээллийг боловсруулахгүйгээр Эстонийн газар нутгаар дамжих хувийн өгөгдөл мэдээлэл
- 4) Энэ хуулийн 1 болон 3 дугаар хэсгийн тайлбарт буй Улсын нууцтай холбоотой хувийн өгөгдөл мэдээлэлд хандах

3. Захиргааны журмын хуулийн хэрэглээ

Энэхүү захиргааны журмын хуулийн нөхцөлийг (RT I 2001, 58, 354; 2002, 53, 336; 61, 375) энэ хуулийн захиргааны хэрэгт хамаарах заалтуудад ашиглан, энэ хуулийн тодорхой заалтуудад авч үзнэ.

4. Хувийн өгөгдөл мэдээлэл

(1) Хувийн өгөгдөл мэдээлэл гэдэг нь аливаа хувь хүнийг физикийн, оюун ухааны, физиологийн, эдийн засаг соёл, эсвэл нийгмийн онцлог, харицаа холбоогоор нь лавлан тодорхойлсон эсвэл тодорхойлж болохтой холбоотой тухайн хүний талаарх мэдээ мэдээлийг хэлнэ.

(2) Хувь хүний нууц өгөгдөл мэдээлэлд дараах мэдээллүүд хамаарна:

- 1) Гэр бүлийн амьдарлын дэлгэрэнгүйг харуулах өгөгдөл мэдээлэл
- 2) Нийгмийн халамж үйлчилгээний нөхцөлийг харуулсан анкет бүхий өгөгдөл мэдээлэл
- 3) Хувь хүний амссан сэтгэл санаа болон бие махбодийн зовиурыг харуулсан өгөгдөл мэдээлэл
- 4) Татварын өр авлагын талаарх өгөгдөл мэдээллийг оруулахгүйгээр, татвар ноогдуулах үеэр хувь хүнд цугласан мэдээ мэдээлэл

(3) Хувийн эмзэг өгөгдөл мэдээлэлд дараах мэдээллүүд хамаарна;

- 1) Хуулинд заасан журмын дагуу хууль ёсны гишүүн байхтай холбоотой өгөгдөл мэдээллийг үл оролцуулан улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, гүн ухааны талаарх итгэл үнэмшилийг харуулсан өгөгдөл мэдээлэл
- 2) Гарал үүсэл үндсэтэн ястанг харуулсан өгөгдөл мэдээлэл
- 3) Эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн байдлыг харуулсан өгөгдөл мэдээлэл
- 4) Генетикийн мэдээллийг харуулсан өгөгдөл мэдээлэл
- 5) Бэлгийн амьдарлыг харуулсан өгөгдөл мэдээлэл
- 6) Үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэлтэй холбоотой өгөгдөл мэдээлэл
- 7) Гэмт хэргийг шүүн таслах ажиллагааны үеэр эсвэл нийтийн шүүх хурлаас өмнө хэргийг мөрдөн шалгах явцад цугласан мэдээ мэдээлэл , эсвэл хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрийн өмнө цуглуулсан баримт мэдээлэл, хэрэв шаардлагатай бол олон нийтийн ёс журмыг хамгаалахын тулд эсвэл гэр бүл хувийн амьдралтай холбоотой хэн нэгэн, эсвэл бага насны хүүхэд, хохирогч, гэрч, шүүгч гэх мэт хүмүүсийн эрх ашиг хөндөгдсөн үед цуглуулагдсан мэдээ мэдээлэл

5. Хувийн өгөгдөл мэдээллийг боловсруулах

Хувийн өгөгдөлийг боловсруулах гэдэг нь хувийн өгөгдөл дээр мэдээллийн цуглуулга хийх, дуу бичлэг, нэгтгэл, хадгалалт, шинэчлэлт, нэвтрэх зөвшөөрөл гаргах, зөвлөгөөн, мэдээллийн сэргээлт, хэрэглээ, дамжуулалт, нийт ашиглалт, хослуулсан нэгтгэл, хаалт, устгал, хасалт хийх гэх мэт эсвэл дээр дурдсан хэд хэдэн үйлдэлд ямар нэгэн байдлаар хандсан эсвэл үйлдэл хийсэн, ашигласан үйл ажиллагааг хэлнэ.

6. Хувийн өгөгдөл мэдээллийн боловсруулалтан дээр ажиллах зарчим

Хувийн өгөгдөл мэдээллийн боловсруулалтанд, хувийн өгөгдлийн албан ёсны ахлах ажилтан /Ерөнхий боловсруулагч/ болон зөвшөөрөл бүхий бусад ажилтан /боловсруулагч/ дараах зарчмыг баримтална:

- 1) Хууль ёсны зарчим – хувийн өгөгдөл мэдээллийг хууль ёсны дагуу шударгаар цуглуулж болно.

- 2) Зорилготой байх зарчим- Хувийн өгөгдөл мэдээллийг зөвхөн тусгай хуулиар зөвшөөрөгдсөн зорилгын хүрээнд цуглуулж болох бөгөөд өгөгдлийг боловсруулахаас татгалзсан албаны тушаал байгаа тохиолдолд хувийн өгөгдөлд хандаж, боловсруулж болохгүй.
- 3) Өчүүхэн бага мэдээлэл авах зарчим – Цугларсан мэдээллийг тодорхой хүрээнд нэмж тодруулах зорилгоор Хувийн өгөгдөл мэдээлэлд хандан цуглуулж болно.
- 4) Хэрэглээний хязгаарлалттай байх зарчим –Хувийн өгөгдөл мэдээллийг бусад зорилгоор эрх бүхий этгээдийн зөвшөөрөлтэйгөөр зөвхөн өгөгдлийн субъекттэй зөвшилцсөний үндсэн дээр ашиглаж болно.
- 5) Өгөгдөл чанартай, үнэн бодитой байх зарчим – Тодорхой зорилгоор өгөгдлийг боловсруулахад шаардлагатай хувийн өгөгдлийг шинэчилж , бүрэн дүүрэн байлгах ёстой.
- 6) Аюулгүй байх зарчим- Аюулгүй байдал нь өгөгдлийг хамгаалхын тулд санаандгүй болон зөвшөөрөлгүй өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх , хувийн өгөгдлийн устгал /гэмтэл/ юм уу илрүүлэлтийг ашиглаж байгаа байдлаар хэмжигдэнэ.
- 7) Бие даасан оролцооны зарчим – Өгөгдлийн субъектцуглуулсан өгөгдөлд тэмдэглэгдэх ёстойгоос гадна тухайн өгөгдлийн субъектэд хамаарах өгөгдлийн хандалтанд тухайн хүнээр баталгаа гаргуулан шаардлагын дагуу буруу ташаа өгөгдлийг засах эрхтэй байна.

7. Албан ёсны ахлах ажилтан /Ерөнхий боловсруулагч/

- 1) Албан ёсны ахлах ажилтан /Ерөнхий боловсруулагч/ гэдэг нь хууль ёсны бодгаль хүн эсвэл хувийн өгөгдлийг боловсруулдаг улсын эсвэл засгийн газрын агентлагын төлөөлөгч эсвэл түүний шаардлагаар хувийн өгөгдлийг боловсруулдаг хүн байна. Албан ёсны ахлах ажилтанг хууль тогтоомж болон журмаар тодорхойлж болно.
- 2) Хэрэв албан ёсны ахлах ажилтанг /Ерөнхий боловсруулагчийг/ өөрөөр хууль болон журмаар тодорхойлоогүй бол дараах байдлаар тодорхойлно:
 - I. Хувийн өгөгдлийг боловсруулах зорилготой
 - II. Хувийн өгөгдлийн тодорхой төрлүүдийг боловсруулна
 - III. Хувийн өгөгдлийг боловсруулах аргын нэг хэлбэр
 - IV. Хувийн өгөгдлийг гуравдагч этгээдэд дамжуулах зөвшөөрөлтэй

8. Зөвшөөрөл бүхий бусад ажилтан /зөвшөөрөл бүхий бусад боловсруулагч/

Зөвшөөрөл бүхий бусад ажилтан/ боловсруулагч/ гэдэг нь хууль ёсны бодгаль хүн эсвэл захиргааны хууль эрх зүй, гэрээний дагуу Ерөнхий боловсруулагчийн шаардсанаар хувийн өгөгдлийг боловсруулдаг улсын эсвэл засгийн газрын агентлагын төлөөлөгч байна. Захиргааны хууль эрх зүй болон гэрээг тодорхойлохдоо хувийн өгөгдлийг боловсруулах нөхцөл, арга хэлбэр , үйл ажиллагаанд нийцүүлнэ.

Зөвшөөрөл бүхий бусад боловсруулагчийг хууль болон журмаар тодорхойлсон байж болно.

9. Өгөгдлийн субъект

Хувийн өгөгдөл мэдээлэл нь боловсруулагдсан хүнийг Өгөгдлийн субъект гэнэ.

10. Гуравдагч хүн

(1) Гуравдагч хүн гэж биет юм уу хууль ёсны хүнийг хэлэх бөгөөд эсвэлдоор зааснаас бусад:

- 1) Албан ёсны ахлах ажилтан /Ерөнхий боловсруулагч/
- 2) Зөвшөөрөл бүхий ажилтан / зөвшөөрөл бүхий боловсруулагч/
- 3) Өгөгдлийн субъект
- 4) Албан ёсны ахлах ажилтан /Ерөнхий боловсруулагч/ юм уу зөвшөөрөл бүхий ажилтаны / зөвшөөрөл бүхий боловсруулагчийн/ харьяанд байдаг өгөгдөл боловсруулдаг улсын эсвэл засгийн газрын агентлагын төлөөлөгч хүнийг хэлнэ.

(2) Ерөнхий боловсруулагчийнгуравдагч этгээдэд гаргаж өгсөн хувийн өгөгдлийг боловсруулж буй гуравдагч этгээдийгэнэ хуулийн 7- ийн (1) гэсэн дэд заалтынхүрээнд тусгагдсанаар ерөнхий боловсруулагч гэж авч үзнэ. Мөн уг гуравдагч этгээд хувийн өгөгдлийг боловсруулах тухай энэ заалт болон бусад хууль тогтоомж , журмыг дагах үүрэгтэй.

Хоёрдугаар хэсэг

Хувийн өгөгдлийг боловсруулах зөвшөөрөл

11. Хувийн өгөгдлийг боловсруулах зөвшөөрөл

- (1) Хуулинд өөрөөр заагаагүй бол зөвхөн өгөгдлийн субъектийн зөвшөөрөлтэйгөөр хувийн өгөгдлийг боловсруулж болно.
- (2) Захиргааны эрх бүхий албан тушаалтан олон улсын гэрээ хэлэлцээр болон хуулинд заасан үүргээ хэрэгжүүлэхийн тулд зөвхөн олон нийтийн даалгавар бүхий системтэй нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хувийн өгөгдлийг боловсруулж болно.

12. Өгөгдлийн субъекттэй зөвшилцсөний үндсэн дээр хувийн өгөгдлийг боловсруулах

- (1) Хувийн өгөгдлийг боловсруулах харилцан зөвшилцөл гэдэг нь Өгөгдлийн субъект нь түүнтэй холбоотой хувийн мэдээлэл нь боловсруулагдах тухайтай танилцаж

өөрийн хүсэлтээр уг мэдээллийг боловсруулахыг зөвшөөрсөн хүсэлтээ тодорхой илэрхийлэхийг хэлнэ.

- (2) Хувийн өгөгдлийг боловсруулахдаа өгөгдлийн субъектийн зөвшилцөлийг хүлээн авахын өмнө ерөнхий боловсруулагч эсвэл зөвшөөрөл бүхий боловсруулагч өгөгдлийн субъектийн доорх зүйлсийг бүртгэнэ;
 - 1) Хувийн өгөгдлийн боловсруулалтын зорилго
 - 2) Хэнд, эсвэл түүний ямар ангилалд зөвшөөрөгдсөн мэдээллийг дамжуулах
 - 3) Ерөнхий боловсруулагчийн эсвэл төлөөлөгчийнх нь нэр болон бизнесийн хаяг
 - 4) Өгөгдлийн субъект хувийн өгөгдлийн боловсруулалтыг зогсоох, алдааг засах, блоклох, устгахыг шаардах эрхтэй бөгөөд ямар тохиолдолд энэ эрхээ эдлэх шалтгаанууд
 - 5) Өгөгдлийн субъект түүнтэй холбоотой хувийн өгөгдөлд хандан мэдээлэл авах эрхтэй бөгөөд ямар тохиолдолд хандаж болох шалтгаанууд
- (3) Өгөгдлийн субъект хэрэв өөрөөр шийдээгүй бол түүнийг амьд байх бүхий л хугацаанд болон нас нөгчсөнөөс хойш 30 жилийн турш түүнтэй хийсэн зөвшилцөл хүчин төгөлдөр байна.
- (4) Өгөгдлийн субъект хэдийд ч зөвшилцөлөө буцаан татгалзаж болно. Буцаан татгалзсан зөвшилцөл буцаж үйлчлэх эрхгүй. Иргэний эрхийн хуулийн(RT I 2002, 35, 216; 2003, 13, 64) ерөнхий хэсэг дэх зорилтын тунхаглалыг агуулсан хуулийн зүйл заалтуудыг зөвшилцөлд нэмэлтээр хэрэглэнэ.
- (5) Маргаан гарсан тохиолдолд, өгөгдлийн субъектийг түүнтэй холбоотой хувийн өгөгдөл мэдээллийн боловсруулахад тохиролцсон зөвшилцөлийг хангаагүй гэж таамаглана.
- (6) Энэ хэсгийг эрх бүхий захиргааны албан тушаалтан хувийн өгөгдөлтэй харьцаж байгаа тохиолдолд хэрэглэхгүйгээс гадна энэ хуулийн 4 (3) дэд хэсэгт заасан эмзэг хувийн өгөгдөл мэдээллийг боловсруулах гэсэн хэсэгт хамаарахгүй.

13. Өгөгдлийн субъект нас нөгчсөний дараа хувийн өгөгдөлийг боловсруулах

- (1) Өгөгдлийн субъект нас нөгчсөний дараа, түүнтэй холбоотой хувийн өгөгдлийг зөвхөн түүний эхнэр нөхөр, эцэг эх, эмээ өвөө, үр хүүхэд, ач зээ, ах эгчийн бичсэн зөвшөөрөлийн бичгээр боловсруулахыг зөвшөөрнө, өгөгдлийн субъект нас нөгчсөнөөс 30 жилийн дараа түүний хувийн өгөгдлийг боловсруулахад зөвшөөрлийн бичиг шаардлагагүй.
- (2) Энэ хэсгийн (1) дэд хэсгийг хэрэв зөвхөн нэр, хүйс, төрсөн он сар өдөр, үхэл, үхлийн баримт мэдээтэй холбоотой хувийн өгөгдлийг боловсруулж байгаа тохиолдолд ашиглахгүй.

14. Өгөгдлийн субъектийн зөвшөөрөлгүйгээр хувийн өгөгдөлийг боловсруулах

- (1) Дараах тохиолдолд өгөгдлийн субъектийн зөвшөөрөлгүйгээр хувийн өгөгдөлдлийг боловсруулахыг зөвшөөрнө:
 - 1) Гэрээний үзүүлэлтэнд өгөгдлийн субъекттэй хамт орсон эсвэл гэрээний үзүүлэлтийг хангаж байгаа
 - 2) Өгөгдлийн субъектийн болон бусад хүний эрх чөлөө, эрүүл мэнд, амьдарлыг хамгаалахад
 - 3) Олон улсын гэрээ хэлэлцээр болон хуулинд заасан үүргээ хэрэгжүүлэхэд
- (2) Өгөгдлийн субъектийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэхувийн өгөгдлийг дамжуулах , өгөгдөлд хандах зөвшөөрөл өгөх:
 - 1) Тухайн этгээдэд хуулинд заасан үүргээ хэрэгжүүлэхийн тулд хувийн өгөгдлийг боловсруулан дамжуулсан бол
 - 2) Өгөгдлийн субъектийн болон бусад хүний эрх чөлөө, эрүүл мэнд, амьдарлыг хамгаалахад
 - 3) Гуравдагч этгээд олон нийтийн эрх ашгийн тулд хуулийн дагуу хязгаарлаагүй мэдээлэлд хандах, түүний үндсэн дээр мэдээлэл шаардсан бол
- (3) Өгөгдлийн субъектийн зөвшөөрөлгүйгээрхувийн эмзэг болон хаалттай өгөгдлийг боловсруулах
 - 1) Олон улсын гэрээ хэлэлцээр болон хуулинд заасан үүргээ хэрэгжүүлэхэд
 - 2) Өгөгдлийн субъектийн болон бусад хүний эрх чөлөө, эрүүл мэнд, амьдарлыг хамгаалахад
- (4) Өгөгдлийн субъектийн зөвшөөрөлгүйгээр эмзэг болон хаалттай хувийн өгөгдлийг гуравдагч этгээдэд дамжуулах , өгөгдөлд хандах зөвшөөрөл өгөх:
 - 1) Тухайн этгээдэд хуулинд заасан үүргээ хэрэгжүүлэхийн тулд хувийн эмзэг болон хаалттай өгөгдлийг боловсруулан дамжуулсан бол
 - 2) Өгөгдлийн субъектийн болон бусад хүний эрх чөлөө, эрүүл мэнд, амьдарлыг хамгаалахад
- (5) Эмнэлэгт байгаа өгөгдлийн субъектийн эрүүл мэндийн байдалтай холбоотой өгөгдлийг түүний ойр дотны хүнд дамжуулж эсвэл тухайн өгөгдөлд тэдгээр хүмүүс доор зааснаас бусад тохиолдолд хандаж болно:
 - 1) Өгөгдлийн субъектийг өгөгдөлд хандахыг эсвэл өгөгдлийг дамжуулахыг хориглосон тохиолдолд
 - 2) Эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Эрүүгийн гэмт хэрэгтэнг саатуулах, хэргийн үйл явдлын үнэнийг тодруулах зорилгоор мөрдөн байцаалтанд байгаа этгээдийн өгөгдөлд хандах, өгөгдөл дамжуулахыг хориглосон байна.

15. Өгөгдлийн субъектийн хувийн өгөгдлийн боловсруулалтын тэмдэглэл

- (1) Хэрэв өгөгдлийн субъект хувийн өгөгдлийн эх үүсвэр биш бол ерөнхий боловсруулагч эсвэл зөвшөөрөл бүхий боловсруулагч хувийн өгөгдлийг

дамжуулахын өмнө эсвэл өгөгдлийн субъект дараах хувийн өгөгдлийн гаргаж авсаны дараа тэмдэглэл хийнэ:

- 1) Хувийн өгөгдлийг боловсруулж буй зорилго
- 2) Хувийн өгөгдлийн эх үүсвэр болон төрөл ангилал
- 3) Хувийн өгөгдлийн дамжуулахыг зөвшөөрсөн хүмүүс болон түүний төрөл ангилал
- 4) Ерөнхий боловсруулагчийн юм уу төлөөгчийн нэр, түүний бизнесийн хаяг
- 5) Өгөгдлийн субъект хувийн өгөгдлийн боловсруулалтыг зогсоох, алдааг засах, блокдох, устгахыг шаардах эрхтэй бөгөөд ямар тохиолдолд энэ эрхээ эдлэх шалтгаанууд
- 6) Өгөгдлийн субъект түүнтэй холбоотой хувийн өгөгдөлд хандан мэдээлэл авах эрхтэй бөгөөд ямар тохиолдолд хандаж болох шалтгаанууд

(2) Энэ хэсгийн (1) дэд хэсэгт заасан заалт доорх тохиолдолд хамаарахгүй:

- 1) Хэрэв өгөгдлийн субъект (1) дэд хэсэгт жагсаасан нөхцөл байдлуудын талаар мэдээлэлтэй байгаа бол
- 2) Хэрэв хувийн өгөгдлийг олон улсын гэрээ хэлэлцээр болон хуулинд заасан үүргээ хэрэгжүүлэхийн тулд боловсруулсан бол
- 3) Энэ хуулийн 30 (1) дэд хэсэгт заасан тохиолдлуудад

16. Хувийн таних код боловсруулах зөвшөөрөл

Олон улсын гэрээ хэлэлцээр, хууль журманд заасны дагуу Өгөгдлийн субъектийн зөвшөөрөлгүйгээр хувийн таних кодыг боловсруулж болно.

17. Мэдээллийг автоматаар боловсруулах шийдвэр

(1) Хэрэв биет хүн, өгөгдлийн субъектийн чадвар боломж болон бусад онцлог шинжийг шийдвэрээр тооцож үнэлсэн, эсвэл энэ нь өгөгдлийн субъектэд хуулийн уршигтай байхаар эсвэл өөр бусад ямар нэгэн аргаар өгөгдлийн субъектэд илт нөлөөлөхүйц байхаар бол бодит хүний оролцоогүйгээр мэдээллийг системээр боловсруулах шийдвэр гаргахыг (цаашид мэдээллийг автоматаар боловсруулах шийдвэр гэнэ) хориглоно. Мөн доорхи тохиолдолуудыг оруулахгүй:

- 1) Гэрээний хэрэгжилт болон гэрээнд орсон зүйл заалтанд өгөгдлийн субъектийн хүсэлтийг оруулсан гэрээний бүлэг заалтанд өгөгдлийн субъект сэтгэл хангалуун, эсвэл өгөгдлийн субъект хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалахын тулд гаргуулсан шийдвэрийн эсрэг эсэргүүцлээ баримтжуулах боломжоо харуулсан тохиолдолд Өгөгдлийн субъектийг хүндэтгэн үзэж мэдээллийг автоматаар боловсруулах шийдвэр гаргана.

- 2) Хэрэв Өгөгдлийн субъектийн хууль ёсны ашиг сонирхолыг хуулиар хамгаалсан байвал мэдээллийг автоматаар боловсруулах шийдвэрийг хуулинд тусгасан байна.
- (2) Мэдээллийг автоматаар боловсруулах шийдвэр гаргахын өмнө өгөгдлийн субъект мэдээллийг автоматаар боловсруулах шийдвэр гаргах үндэслэл болсон өгөгдөл боловсруулах нөхцөлөө Хоёрдмол утгагүйгээр нэг утгаар илэрхийлсэн мэдэгдэлээр гаргана.

Гуравдугаар хэсэг

Хувийн өгөгдлийг боловсруулах шаардлага, хувийн өгөгдлийг хамгаалах аюулгүй байдлын хэмжүүр

18. Хувийн өгөгдлийг боловсруулах шаардлагууд

Хувийн өгөгдлийг боловсруулахдаа ахлах боловсруулагч болон зөвшөөрөл бүхий боловсруулагчид:

- 1) Хуулинд өөрөөр заагаагүй бол өгөгдсөн зорилгод шаардлагагүй хувийн өгөгдлийг хугацаанд нь шууд устгана эсвэл блоклоно.
 - 2) шаардлагатай бол өгөгдсөн зорилгыг биелүүлэхдийн тулд хувийн өгөгдлийг шинэчилж, зөв байлгах баталгааг хангана.
 - 3) Алдаатай бүрэн дүүрэн бус хувийн өгөгдлийг хааж өгөгдлийн алдааг засаж сайжруулах шуурхай арга хэмжээ авна.
 - 4) Алдаатай өгөгдлийг үнэн зөв мэдээллийг ашиглаж байсан үетэй нь хамт тэмдэглэл үйлдэн хадгална.
 - 5) Үнэн зөв эсэх нь маргаантай хувийн өгөгдлийг үнэн зөв гэдэг нь батлагдах хүртэл эсвэл үнэн эсэхийг тодорхойлох хүртэл хаана.
19. Хувийн өгөгдлийг хамгаалах зохион байгуулалтын, биет болон Мэдээллийн аюулгүй байдлын хэмжүүрүүд

- (1) Хувийн өгөгдлийг хамгаалхын тулд ахлах болон зөвшөөрөл бүхий боловсруулагчид зохион байгуулалтын, биет болон мэдээллийн аюулгүй байдлын хэмжүүрийг авах шаардлагатай.
 - 1) Өгөгдлийн нэгдмэл байдлын хувьд өгөгдөлд зөвшөөрөгдөөгүй, санаатай, гэнэтийн өөрчлөлт орохын эсрэг байна.
 - 2) Өгөгдлийн хүртээмжтэй байдлын хувьд гэнэтийн алдалт болон санаатай устгалын эсрэг байна, мөн эрх бүхий этгээдийн төлөө өгөгдөлд хандахаас хамгаалах байр суурьтай байна.
 - 3) Өгөгдлийн нууцлалтын хувьд зөвшөөрөгдөөгүй боловсруулалтын эсрэг байна.
- (2) Ахлах болон зөвшөөрөл бүхий боловсруулагчид хувийн өгөгдөлд хандахдаа дараах шаардлагыг хангаж ажиллана:

- 1) Зөвшөөрөлгүй этгээд хувийн өгөгдөл боловсруулдаг тоног төхөөрмжинд хандахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах
 - 2) Зөвшөөрөлгүй унших, хуулж авах болон өгөгдөл боловсруулдаг системд өөрчлөлт оруулах, дундын өгөгдлийг зөвшөөрөлгүй устгахаас зайлсхийх
 - 3) Зөвшөөрөлгүй дуу бичлэг хийх, хувийн өгөгдөл устгах, өөрчлөлт орохоос урьдчилан сэргийлэх, мөн дараа нь хэзээ, хэнд, ямар хувийн өгөгдөлийг тэмдэглүүлсэн, өөрчилсөн, устгасаныг тодорхойлох боломжтой байх баталгааг хангах
 - 4) Өгөгдөл боловсруулах системийн хэрэглэгч бүр хувийн өгөгдөлд хандах зөвшөөрөгдсөн ганц эрхээрээ зөвхөн өөрөө нэвтэрч байгаа эсэх баталгааг хангах
 - 5) Ямар хувийн өгөгдлийг хэзээ, хэнд дамжуулж байсан болон иймэрхүү өгөгдлийн өөрчлөгдөөгүй хадгалалтийн мэдээ мэдээлийн бүрэн бүтэн байдлыг хангах
 - 6) Өгөгдөл дамжуулах тоног төхөөрөмж болон дундын өгөгдлийн тээвэрлэлтээр дамжин хувийн өгөгдөл зөвшөөрөлгүй уншигдах, хуулж авах болон өгөгдөл боловсруулдаг системд өөрчлөлт орох, устгал хийгдэхгүй байх баталгааг хангана.
 - 7) Аж ахуй нэгж, төрийн албан байгууллага, агентлаг, нэгдэл холбоодын ажлыг зохион байгуулахдаа өгөгдөл хамгаалах нөхцөл шаардлагуудыг дагаж мөрдөх боломжтой байдлаар зохицуулна.
- (3) Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчид өөрсдийн хяналтан дор хувийн өгөгдлийг боловсруулдаг тоног төхөөрөмж болон програм хангамж дээрх тэмдэглэлүүдийг хадгалж байх шаардлагатай бөгөөд эдгээр тэмдэглэл нь дараах мэдээллийг агуулсан байна:
- 1) Тоног төхөөрөмжийн нэр, төрөл, байршил болон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн нэр
 - 2) Програм хангамжийн загварын нэр, үйлдвэрлэгчийн нэрний дэлгэрэнгүй болон програм хангамжийн баримт гэрчилгээний байршил

20. Хувийн өгөгдөл боловсруулдаг хүмүүст тавигдах шаардлага

- (1) Ерөнхий боловсруулагч юм уу зөвшөөрөл бүхий боловсруулагчийн удирдлаганд харьялагддаг хувийн өгөгдөл боловсруулагчид нь энэ хуулинд заасан нөхцөл шаардлага, зорилтууд болон ерөнхий боловсруулагчийн заавар тушаалын дагуу ажиллах үүрэгтэй.
- (2) Энэ хэсгийн (1) дэд хэсэгт заасан хүмүүс нь ажил үүргээ гүйцэтгэх явцдаа мэдэж авсан хувийн өгөгдлийн нууцыг хадгалах үүрэгтэй төдийгүй өгөгдөлтэй холбоотой ажил үүргээ гүйцэтгэсний дараа болон үйлчилгээтэй холбоотой ажиллах хугацаа дууссаны дараа ч гэсэн хувийн өгөгдлийн нууцыг сахих үүрэгтэй.

- (3) Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчид өөрсдийн харьяанд дадлага хийж буй хувийн өгөгдөл боловсруулж буй хүмүүстэй ажиллахдаа хувийн өгөгдлийн хамгаалалтийн баталгааг ханган ажиллах шаардлагатай.

Дөрөвдүгээр хэсэг

Хувийн өгөгдлийн боловсруулалтийн тэмдэглэл

21. Тэмдэглэл хийх үүрэг

- (1) Хувийн өгөгдлийн ерөнхий боловсруулагч нь тодорхой шалгуурын үндсэн дээр хувь хүний нууц өгөгдөлийг компьютерт дижитал хэлбэрээр юм уу цаасан дээр амархан хэрэглэж, хандаж болохоор хэлбэрээр боловсруулах бол хувь хүний нууц өгөгдөл боловсруулалтыг Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад тэмдэглүүлэх шаардлагатай.
- (2) Тэмдэглэл, бүртгэл хийх үүрэг нь хэрэв хувийн өгөгдлийг хууль журмын дагуу эсвэл үндэсний ерөнхий бүртгэл болон улсын бүртгэлд боловсруулж байгаа тохиолдолд хамаарахгүй.

22. Хувийн өгөгдлийн боловсруулалттай холбоотой тэмдэглэл

- (1) Энэ хуулийн 21 (1) –д заасан тэмдэглэл, бүртгэл хийх үүргээ хэрэгжүүлэхийн тулд хувийн өгөгдлийн ерөнхий боловсруулагч нь хувь хүний нууц өгөгдөл боловсруулахтай холбоотой (Цаашид бүртгэл, тэмдэглэл гэнэ) тэмдэглэл оруулна.
- (2) Хувийн өгөгдлийн боловсруулалттай холбоотой тэмдэглэлийг хувийн өгөгдлийн боловсруулалт эхлэхээс хамгийн багадаа нэг сарын өмнө хувийн өгөгдлийн боловсруулалтын бүртгэлд дижиталаар оруулна.
- (3) Тэмдэглэл нь дараах мэдээллийг харуулна:
 - 1) Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчийн нэр, бүртгэлийн код юм уу хувийн таних код, бизнесийн газар, оршин суугаа хаяг болон бусад дэлгэрэнгүй (шуудангийн хаяг, утасны дугаар, мэйл хаяг гэх мэт)
 - 2) Хувийн өгөгдлийг боловсруулж буй зорилго
 - 3) Хувийн өгөгдлийн төрөл анги
 - 4) Өгөгдөл нь боловсруулагдах хүмүүсийн төрөл ангилал
 - 5) Хувийн өгөгдлийн эх сурвалж
 - 6) Хувийн өгөгдлийг дамжуулж болох хүмүүс болон тэдгээрийн төрөл
 - 7) Хувийн өгөгдлийг гадны улсад дамжуулах нөхцөл
 - 8) Хувийн өгөгдлийн хаах, хасах, устгах нөхцөл

9) Энэ хуулийн 19 (2) дэд хэсэгт заасан хувийн өгөгдлийг хамгаалах зохион байгуулалтын, биет болон мэдээллийн аюулгүй байдлын хэмжүүрүүдийн ерөнхий тодорхойлолт

(4) Тэмдэглэл хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэлд орсоноор тэмдэглэл бүртгэл хийх үүрэг хэрэгжсэн гэж үзнэ.

23. Өгөгдөлийн өөрчлөлтийн талаарх тэмдэглэл

Ерөнхий боловсруулагч энэ хуулийн 22-т заасан заалтын дагуу хувийн өгөгдөлд өөрчлөлт засвар оруулах үүргээ хэрэгжүүлэхийн өмнө хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэлд орсон өгөгдлийн өөрчлөлт сайжруулалтийг Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад тэмдэглүүлэх шаардлагатай.

Тавдугаар хэсэг

Хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалтын бүртгэл

24. Хувийн эмзэг өгөгдөл мэдээллийг бүртгэх үүрэг

- (1) Ерөнхий боловсруулагчид хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалтыг Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад бүртгүүлэх шаардлагатай.
- (2) Хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалттай холбоотой идэвхтэй хамрах хүрээнд энгийн лиценз болон идэвхтэй лицензний хүсэлт гаргадаг ерөнхий боловсруулагч лиценз авах хүсэлт гаргахын өмнө Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад бүртгүүлэх шаардлагатай. Хэрэв хувийн өгөгдлийн боловсруулалт бүртгэгдээгүй бол идэвхтэй болон энгийн лиценз олгогдохгүй.
- (3) Хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалт нь 5 жилийн хугацаатай бүртгэгдэнэ. Хугацаа дуусахаас дор хаяж 3 сарын өмнө энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу ерөнхий боловсруулагч шинэ бүртгэлийн хүсэлт оруулах шаардлагатай. Хугацаа дууссаны дараа ерөнхий боловсруулагч хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалтанд хандах эрхээ алдана.
- (4) Дараах тохиолдолд хувийн эмзэг өгөгдөл мэдээллийг боловсруулахыг хориглоно.
 - 1) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад гаргасан хувийн эмзэг өгөгдөл мэдээлэл боловсруулах зөвшөөрөл амжилтгүй болсон бол
 - 2) Хэрэв хувийн эмзэг өгөгдөл мэдээллийг боловсруулах бүртгэлийн хугацаа дууссан, ерөнхий боловсруулагч шинэ бүртгэлийн хүсэлт оруулаагүй бол
 - 3) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалтанд хориг тавьсан эсвэл түдгэлзүүлсэн бол
- (5) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагадараах тохиолдолд хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалтыг бүртгэхээс татгалзана.
 - 1) Өгөгдлийг боловсруулах хууль зүйн үндэслэл байхгүй бол

- 2) Өгөгдөл боловсруулах нөхцөл нь энэ хуулийн болон түүнтэй холбоотой гарсан бусад хууль тогтоомжийн шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд
- 3) Хавсралтийн хувийн өгөгдлийг хамгаалах зохион байгуулалтын, биет болон мэдээллийн технологийн аюулгүй байдлын хэмжүүрүүд нь энэ хуулийн 19 т заасан шаардлагуудыг хангахгүй байгаа тохиолдолд

25. Бүртгүүлэх хүсэлт гаргах

- (1) Бүртгэлийн хүсэлтийг хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэлд оруулахдаа Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллын веб сайтад дижитал хэлбэрээр хувийн эмзэг өгөгдлийн боловсруулалт эхлэхээс дор хаяж нэг сарын өмнө оруулна.
- (2) Бүртгүүлэх хүсэлт нь дараах мэдээллийг харуулсан байна:
 - 1) Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчийн нэр, бүртгэлийн код юм уу хувийн таних код, бизнесийн газар, оршин суугаа хаяг болон бусад дэлгэрэнгүй (шуудангийн хаяг, утасны дугаар, мэйл хаяг гэх мэт)
 - 2) Хувийн өгөгдлийг боловсруулж буй зорилго
 - 3) Хувийн өгөгдлийн төрөл анги
 - 4) Өгөгдөл нь боловсруулагдах хүмүүсийн төрөл ангилал
 - 5) Хувийн өгөгдлийн эх сурвалж
 - 6) Хувийн өгөгдлийг дамжуулж болох хүмүүс болон тэдгээрийн төрөл
 - 7) Хувийн өгөгдлийг гадны улсад дамжуулах нөхцөл
 - 8) Энэ хуулийн 19 (2) дэд хэсэгт заасан хувийн өгөгдлийг хамгаалах зохион байгуулалтын, биет болон мэдээллийн аюулгүй байдлын хэмжүүрүүдийн дэлгэрэнгүй тодорхойлолт

26. Бүртгэлийн хүсэлтийг боловсруулах нь

- (1) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь бүртгүүлэх хүсэлт гаргасан өдрөөс ажлын 20 хоногийн дотор хүсэлтийг бүртгэнэ эсвэл бүртгэхээс татгалзана.
- (2) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь хувийн өгөгдлийн боловсруулалтын бэлэн байдлыг газар дээр нь шалгаж болно. Энэ тохиолдолд бүртгэлийн хүсэлтийг хүлээн зөвшөөрөх хугацаа ажлын 10 хоногоор сунгагдана. Шалгалтын үр дүнд Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь хүсэлт болон хувийн өгөгдлийг хамгаалах зохион байгуулалтын, биет болон мэдээллийн технологийн аюулгүй байдлын хэмжүүрүүд дээр санал зөвлөмж өгч болно.
- (3) Ерөнхий боловсруулагчийн хувийн эмзэг өгөгдөл мэдээллийг боловсруулах эрх энэ хэсгийн (1) дэх дэд хэсэгт заасан шийдвэрээр тодорхойсон өдрөөс үүснэ. Хэрэв энэ хэсгийн (1) дэх дэд хэсэгт заасан шийдвэрээр хугацааг тодорхой заагаагүй бол ерөнхий боловсруулагчийн хувийн эмзэг өгөгдөл мэдээллийг

боловсруулах эрх нь хувийн өгөгдлийн боловсруулагчийн бүртгэлд бүртгүүлэх дараагийн өдөр хүртэл үргэлжилнэ.

(4) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын вебсайт дээр тавигдсан тодруулгаар ерөнхий боловсруулагчид хувийн эмзэг өгөгдөлийг боловсруулах эрх хүссэн бүртгүүлэх шийдвэр очсон гэж үзнэ.

(5) Бүртгэхээс татгалзсан шийдвэртэй холбоотой тэмдэглэгээг хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэлд хийж хүсэлт гаргагчийг тэмдэглэнэ.

27. Хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэл

(1) Хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэл гэдэг нь Бүгд найрамдах Эстони улсын засгийн газрын тогтоосон бүртгэл бүхий хувь хүний нууц өгөгдөлийн боловсруулалт болон хувийн эмзэг өгөгдөлийн боловсруулалтын бүртгэлийн мэдээ мэдээлэлтэй холбоотой журмын дагуу Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын үүсгэсэн бүртгэлийн бааз юм.

(2) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад орсон хувийн өгөгдлийг хамгаалах зохион байгуулалтын, биет болон мэдээллийн технологийн аюулгүй байдлын хэмжүүрүүдтэй холбоотой мэдээ мэдээлэл болон хувийн өгөгдлийг хаах, устгах нөхцөлтэй холбоотой мэдээллийг дотоод хэрэглээнд зориулсан мэдээ мэдээлэл гэж үзнэ.

(3) Бүртгэл гэдэг нь Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын олон нийтэд зориулсан веб сайт дээрх энэ хэсгийн (2) дэд хэсэгт заасан мэдээлэл болон аюулгүй байдлын баталгааны хүрээнд хувийн өгөгдлийг боловсруулахтай холбоотой мэдээ мэдээлэлээс гадна бусад мэдээ мэдээллийг хэлнэ.

(4) Бүртгэлд орсон өгөгдөл мэдээлэл нь утга учиртай байна. Хувийн эмзэг өгөгдөл боловсруулалтын бүртгэлтэй холбоотой бичилтүүд нь хууль зүйн агуулгатай байна.

Зургаадугаар хэсэг

Гадны улсуудад хувийн өгөгдөл мэдээллийг дамжуулах нь

28. Гадны улсуудад хувийн өгөгдөл мэдээллийг дамжуулах нь

(1) Эстони улсад байршиж байгаа өгөгдлийн баазаас хувийн өгөгдлийг гадны улс руу маш сайн хамгаалалтын түвшинд дамжуулж болно.

(2) 2014.04.14-нд орж 2044.05.01-нд хүчин төгөлдөр болсон - RTI 2004-0-208-хүчингүй болсон

(3) Хувийн өгөгдлийг Европын холбооны улсууд, Европын эдийн засгийн бүс нутгийн хамтын ажиллагааны гэрээнд оролцогч улсууд болон Европын холбооны комиссоор өгөгдлийн хамгаалалтын түвшинг хангалттай гэж үзсэн улс орнууд

руу дамжуулахыг зөвшөөрнө. Европын холбооны комиссоор өгөгдлийн хамгаалалтын түвшинг хангалтгүй гэж үзсэн улс орнууд руу хувийн өгөгдөл дамжуулахыг зөвшөөрөхгүй.

- (4) Хувийн өгөгдлийг энэ хэсгийн (1) дэд хэсэгт заасан нөхцөлийг хангаагүй улс орон луу зөвхөн Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын зөвшөөрөлтэйгөөр дамжуулж болно.
- 1) Хэрэв, онцгой тохиолдолд, ерөнхий боловсруулагч тухайн улсад амьдарч буй өгөгдлийн субъектийн хувийн амьдрал болон эрхийг батлан дааж байгаа бол
 - 2) Хувийн өгөгдлийг дамжуулах онцгой тохиолдолд,
 - тухайн улсын өгөгдөл хамгаалах түвшин хангалттай нь батлагдсан байх.

Өгөгдлийн хамгаалалтын түвшиний үнэлгээн дээр:

- хувийн өгөгдлийг дамжуулахтай холбоотой тохиолдлууд,
 - өгөгдлийн төрөл ангийг оролцуулаад ,
 - өгөгдлийг боловсруулах хугацаа болон зорилго,
 - тухайн улсад өгөгдлийг дамжуулах цэг (газар) болон тухайн эцсийн улсад очих цэг,
 - тухайн улсын хуулийг авч үзнэ.
- (5) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь энэ хэсгийн (4) дэх дэд хэсгийн дагуу Европын холбооны комиссоос зөвшөөрсөн шийдвэрийг мэдээллэнэ.
- (6) Дараах тохиолдолд өгөгдлийн хамгаалалтын түвшин хангалттай нь батлагдаагүй гадны улс орон руу Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын зөвшөөрөлгүйгээр хувийн өгөгдлийг дамжуулж болно.
- 1) Энэ зорилгоор өгөгдлийн субъекттэй зөвшилцсөн бол
 - 2) Энэ хуулийн 14 (2) дэд хэсэгт заасан тохиолдлуудад
 - 3) Хэрэв өгөгдлийг гадны улс руу криптографик хэлбэрээр дамжуулж байгаа бол, мөнтухайн улсад код тайлах шаардлагатай өгөгдөлийг мэдээллээгүй бол

Долдугаар хэсэг

Өгөгдлийн субъектийн эрх

29. Өгөгдлийн субъектийн хувийн өгөгдөлийн боловсруулалт дахь түүнтэй холбоотой өгөгдөл мэдээлэлийг хүлээж авах эрх

- (1) Өгөгдлийн субъектийн шаардсанаар ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчид өгөгдлийн субъектийн дараах зүйлсийг тэмдэглэж авна:
- 1) Түүнтэй холбоотой хувийн өгөгдөл
 - 2) Хувийн өгөгдлийг боловсруулах зорилго
 - 3) Хувийн өгөгдлийн төрөл ангилал, эх сурвалж
 - 4) Хувийн өгөгдлийг дамжуулахыг зөвшөөрсөн 3 дагч этгээд болон түүний төрөл ангилал

- 5) Ерөнхий боловсруулагчийн бизнесийн газрын нэр болон хаяг
- (2) Өгөгдлийн субъект ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчаас өөртэйгээ холбоотой хувийн өгөгдөлийн хуулбарыг хүлээн авах эрхтэй. Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагч хуулбарын эхний 20 хуудаснаас эхлээд хуудас бүрийг 3 кроноор үнэлж болно. Хувийн өгөгдөл хэвлэхийг зөвшөөрсөн хураамжийг мөн адил хувийн өгөгдлийг дахин хэвлэхийг зөвшөөрсөний төлөө дахин үнэлж болно.
- (3) Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагч хүсэлт хүлээн авсанаас хойш ажлын 5 өдрийн дотор өгөгдлийн субъектийг шаардсан хувийн өгөгдөлтэй холбоотой мэдээлэл болон хүссэн өгөгдөл мэдээллийг нь өгөхөөс татгалзсан шалтгаан гэх мэт мэдээллээр хангах шаардлагатай.

30. Хувийн өгөгдөл болон мэдээ мэдээлэл хүлээн авах эрхийг хасах тухай

- (1) Дараах эргэлзээ илэрсэн тохиолдолд өгөгдлийн субъектийн өөрийн холбогдолтой хувийн өгөгдөл болон мэдээ мэдээлэл хүлээн авах эрх хязгаарлагдана:
- 1) Бусад хүмүүсийн эрх, эрх чөлөө
 - 2) Хүүхдийн эцгийг тогтоох нууцлалын хамгаалалт
 - 3) Эрүүгийн хэрэг болон эрүүгийн гэмт хэрэгтнээс болгоомжлох, урьдчилан сэргийлэх
 - 4) Гэмт хэргийн явцын үнэнийг тогтоох
- (2) Ерөнхий боловсруулагч өгөгдөл болон мэдээ мэдээлэл өгөхөөс татгалзах шийдвэр гаргана, мөн түүний өгөгдлийн субъектийг мэдээллэнэ.

31. Өгөгдлийн субъектийн хувийн өгөгдлийн алдааг засах, хаах, устгах болон хувийн өгөгдлийн боловсруулалтыг хүчингүй болгохыг шаардах эрх

- (1) Хэрэв өгөгдлийн боловсруулалт нь энэ хууль болон энэ хуулийн үндсэн дээр гарсан бусад хууль тогтоомжийн эсрэг байвал ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагч өгөгдлийн субъектийн шаардсанаар:
- 1) Өгөгдлийн субъекттэй холбоотой хувийн өгөгдлийн боловсруулалтыг эцэслэн зогсооно.
 - 2) Алдаатай буруу хувийн өгөгдлийг засаж сайжруулна.
 - 3) Цугласан хувийн өгөгдлийг хаана эсвэл устгана.
- (2) Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагч өгөгдлийн субъект болон гуравдагч этгээдэд дамжуулсан алдаатай хувийн өгөгдлийн засварын тухай болон хаасан, устгасан хувийн өгөгдөлийн талаарх мэдээлийг тэдэнд нэн даруй мэдэгдэнэ.

(3) Энэ хэсгийн (2) дахь дэд хэсэгт заасан үүрэг нь дараах тохиолдолд хэрэгсэхгүй:

- 1) Хэрэв өгөгдлийн субъект (2) дэд хэсэгт жагсаасан учир шалтгаануудыг мэдэж байгаа бол
- 2) Энэ хуулийн 30 (1) дэд хэсэгт заасан тохиолдлуудад
- 3) Хэрэв Өгөгдлийн субъектэд мэдээллэх мэдэгдэл нь пропорциональ бус хэмжээний хүндрэл дагуулахаар байвал

32. Өгөгдлийн субъектийн Өгөгдөл хамгаалах Хяналтын Байгууллага болон шүүхэд сөрөг мэдүүлэг гаргах эрх

Өгөгдлийн субъект хувийн өгөгдлийн боловсруулалтанд өөрийнх нь эрх зөрчигдсөнийг олж мэдсэн бол Өгөгдөл хамгаалах Хяналтын Байгууллага болон шүүхэд сөрөг мэдүүлэг гаргах эрхтэй.

33. Өгөгдлийн субъектийн хохиролдоо нөхөн төлбөр шаардах эрх

Хэрэв хувийн өгөгдлийн боловсруулалтанд өгөгдлийн субъектийн эрх зөрчигдсөн байвал өгөгдлийн субъект хохирсон учралдаа нөхөн төлбөр шөөрдөх эрхтэй:

- 1) Улсын мөнгөн өрийн тухай хуульд заасан журмын дагуу болон хуулийн үндсэн дээр (RT I 2001, 47, 260; 2002, 62, 377) Хэрэв олон нийтийн даалгавар бүхий системтэй нэгдсэн удирдлагаар эрх нь зөрчигдсөн бол эсвэл
- 2) Үүрэг хариуцлагын тухай хуулинд заасан журмын дагуу болон хуулийн үндсэн дээр (RT I 2001, 81, 487; 2002, 60, 374) хэрэв хувийн эрх зүйн харилцан хамаарлаар эрх нь зөрчигдсөн бол

Наймдугаар хэсэг

Хяналт

34. Хяналт

- (1) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь энэ хууль болон энэ хуулийн үндсэн дээр үүссэн хууль тогтоомжид нийцүүлэн хянах үйл ажиллагаа явуулна.
- (2) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь өөрийн санаачлагаар болон гомдол хүлээн авсаны үндсэн дээр хяналтыг эхлүүлж болно.
- (3) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь хяналт тавьдаг байгууллагын хувьд бие даасан шижтэй бөгөөд энэ хууль болон энэ хуулийн үндсэн дээр гарсан бусад хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

35. Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын удирдлагад тавигдах шаардлагагууд

- (1) Хууль зүйн чиглэлээр хангалттай дадлага хуримтлуулсан, Менежмент, Мэдээллийн технологийн удирдлага болон аудитийн туршлага бүхий дээд боловсролтой хүн Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын удирдлагаар ажиллаж болно.
- (2) Санаатай эрүүгийн гэмт хэргээр ял эдэлж байсан, эсвэл ямар нэгэн албан тушаалаас чөлөөлөгдөж байсан, эсвэл боловсролын улмаас ажлын байранд тэнцэх шаарлагыг хангахгүй цаашид үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болж байсан хүн Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын удирдлага байж болохгүй.
- (3) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага багшлах болон судалгаа хийх ажлыг оролцуулахгүйгээр удирдлагын удирдах хугацааны туршид ямар нэгэн өндөр цалинтай өөр бусад албан тушаалыг байлгахгүй.
- (4) Бүгд найрамдах Естони улсын засгийн газар Дотоод хэргийн яамны саналаар Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын удирдлагыг 5 жилийн хугацаатай томилно.

36. Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын гүйцэтгэх үүрэг

- (1) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь:
 - 1) Энэ хуулинд заасан шаарлагад нийцүүлэн хянах үйл ажиллагаа явуулна.
 - 2) Хуулинд заасан журмын дагуу тодорхой заагт албадлагын хүчийг хэрэглэнэ.
 - 3) Шаардлагатай бол жижиг гэмт хэргийн эхний явцад шийтгэл ноогдуулна.
 - 4) Өгөгдөл хамгаалах олон улсын хяналтын байгууллага болон гадаадын өгөгдөл хамгаалах хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан, бусад гадны чадварлаг эрх бүхий албан тушаалтануудтай хамтран ажиллах
 - 5) Энэ хуулийг хэрэгжүүлэх заавар, санал зөвлөмжөөр хангана.
 - 6) Хуулийн дагуу үүссэн бусад үүргийг хэрэгжүүлнэ.
- (2) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэх энэ хууль болон энэ хуультай холбоотой гарсан бусад хууль тогтоомжинд заасан бүх эрх байгаа бөгөөд мөн дараах эрхтэй:
 - 1) Хувийн өгөгдлийн боловсруулалтыг түдгэлзүүлэх
 - 2) Алдаатай буруу хувийн өгөгдлийн алдааг засаж сайжруулахыг шаардах
 - 3) Хувийн өгөгдлийн боловсруулалтыг хориглох
 - 4) Хувийн өгөгдлийн боловсруулалтыг хаах, эсвэл хүчингүй болгохыг шаардах (архивт орсон эсвэл архиваас утсан хувийн өгөгдлийг оролцуулна)
 - 5) Шаардлагатай бол хүмүүсийн эрх, эрх чөлөөнд хохирол учирхаас сэргийлэхийн тулд Торгуулийн / ялын/ (Penalty payment act) (RT I 2001, 50, 283; 94, 580) төлбөрийн тухай хууль болон Хууль сахиулах орлуулалтын тухай хуулинд (Substitutive Enforcement act) заасан журмын дагуу хувийн өгөгдлийг хамгаалах зохион байгуулалтын, биет болон мэдээллийн технологийн хэмжүүрүүдийг шууд хэрэглэнэ.

- б) Хувь хүнээс бусад шаардлагатай мэдээ мэдээлэл , холбогдох баримт болон баримт хувилж авахыг шаардах
- (3) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын нэр хүндтэй, эрх бүхий албан тушаалтан ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчийн өрөө эсвэл ажлын талбарыг шалган байцааж чөлөөтэй саадгүй нэвтрэх, Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчийн баримт бичиг, тоног төхөөрөмжинд болон хадгалагдсан өгөгдөл ,өгөгдөл боловсруулахад ашигладаг программ хангамжинд нэвтрэн мэдээлэл олж авах эрхтэй.

37. Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын хүлээсэн үүрэг

Албан ёсны Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь

- 1) Энэ хууль болон энэ хуулийн үндсэн дээр гарсан бусад хууль тогтоомжид нийцүүлэн;
- 2) Тодорхой заагаагүй нөхцөлд ажил үүргээ гүйцэтгэх явцдаа мэдэж авсан хувийн өгөгдөл болон хязгаарласан мэдээ мэдээллийн нууцыг хадгалах;
- 3) Шалгуулж байгаа хүний шаардлагаар бичиг баримтаа үзүүлэх;
- 4) Хяналтын үр дүн дээр шалгалтын тайлан бэлтгэх;
- 5) Хувийн өгөгдөлийн боловсруулалтан дээр тавигдах шаардлагад зөрчил илэрсэн тохиолдолд ерөнхий болон зөвшөрөл бүхий боловсруулагч эсвэл тэдний төлөөлөгчид зөрчлийн үндсэн шалтгааныг тайлбарлаж зөрчлөө арилгахыг шаардах;
- 6) Хувийн өгөгдөлийн боловсруулалтан дээр тавигдах шаардлагад зөрчил илэрсэн, мөн жижиг зөрчлүүд үүссэн тохиолдолд дагаж мөрдөх заавар гаргана.

38. Санал гомдлыг авч хэлэлцэх нөхцөл

- (1) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь ирсэн санал гомдлыг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэнэ.
- (2) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь санал гомдлыг шийдхийн тулд нэмж тодруулах баримт цуглуулах шаардлагатай болсон тохиолдолд санал гомдлыг авч хэлэлцэх хугацааг дахин 60 өдрөөр сунгаж болно. Гомдол гаргагчийг хугацаа сунгасан бичигт бүртгэнэ.

39. Хяналт шалгалтын тайлан

- (1) Хяналт шалгалтын тайланг хувийн өгөгдөл боловсруулах шаардлагад нийцүүлэн хяналт шинжилгээ явуулсаны үндсэн дээр бэлтгэнэ.
- (2) Хяналт шалгалтын тайлан нь дараах мэдээллийг харуулна:
 - 1) Тайлан бэлтгэж байгаа хүний овог нэр, албан тушаал;

- 2) Тайлан хаяглагчийн овог нэр, хаяг эсвэл хуулийн этгээдийн нэр болон шуудангийн хаяг;
- 3) Баримт бичгийн агуулга (Хуулийн үндэслэл, тогтоогдсон баримт нотолгоонууд, ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагч эсвэл тэдний төлөөлөгчдийн тайлбар, хэрэгтэй холбоотой бусад баримтууд)
- 4) Тайланг бэлтгэж буй газар болон он, сар, өдөр
- 5) Тайлан бэлтгэсэн хүний гарын үсэг

40. Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын мөрдөх журам

- (1) Энэ хуулийн дүрэм журмыг хангахын тулд Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын албан тушаалтан ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагчид заавар болон шийдвэр гаргах эрхтэй.
- (2) Энэ хэсгийн (1) дэд хэсэгт заасан зааврын хэрэгжилт амжилтгүй болсон тохиолдолд Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь Торгуулийн төлбөрийн тухай хууль болон Хууль сахиулах орлуулалтын тухай хуулинд (Substitutive Enforcement act) заасан журамд нийцүүлэн торгуулын ял ногдуулж болно.
- (3) Энэ хэсгийн (2) дэд хэсэгт заасан торгуулын төлбөрийн дээд хэмжээ 10 000 kroon байна. (ойрлцоогоор 860 доллар 2003 оны үед)
- (4) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын хувийн өгөгдөл боловсруулах эрхийг түдгэлзүүлэх , хувийн өгөгдлийн боловсруулалтанд тавьсан хориг болон цуцлалттай холбоотой гаргасан заавар болон шийдвэрийг хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэлд оруулна.

41. Энэ хуулинд нийцсэн Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын тайлан

- (1) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага нь энэ хуулинд нийцүүлэн гаргасан тайлангаа жил бүрийн 12 сарын 01- нд Riigikogu –ийн Үндсэн хуулийн хороо болон Хууль зүйн сайдад танилцуулна.
- (2) Тайлан нь энэ хуулийн хэрэгжилтийн дагуу болон хэрэгжилттэй холбоотой ажлын байдлын үндсэн чухал хэсгүүдийн ерөнхий байдалыг агуулсан оршилтой байна.
- (3) Тайланг Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагын веб сайт дээр нийтлэнэ.

Есдүгээр хэсэг

Хариуцлага

42. Энэ хуулийн шаардлагуудын зөрчилийн тухай

- (1) Хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалтыг бүртгүүлэх үүргээ зөрчсөн, хувийн өгөгдлийг хамгаалах аюулгүй байдлын хэмжүүрийн тухай шаардлагуудыг зөрчсөн, эсвэл хувийн өгөгдлийн боловсруулалтын бусад шаардлагыг зөрчсөн зөрчилийг 300 хүртэл торгуулын нэгжээр торгох шийтгэл ноогдуулна.
- (2) Мөн адил хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол 50,000 хүртлэх Эстони kroon – ээр торгох шийтгэл ноогдуулна.
- (3) Энэ хэсэгт заасан жижиг гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн эмхтгэлийн ерөнхий хэсгийн зүйл заалтууд (RT I 2001, 61, 364; 2002, 82, 489; 86, 504; 105, 612; 2003, 4, 22) болон жижиг гэмт хэргийн хуулийн журмын эмхтгэлийг хэрэглэнэ.
- (4) Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллага энэ хэсэгт заасан жижиг гэмт хэргийн явцыг хариуцсан нэмэлт шүүгчтэй байна.

Аравдугаар хэсэг

Хуулийн заалтыг хэрэгжүүлэх нь

43. Өгөгдлийн баазын хуулийн нэмэлт өөрчлөлт

Өгөгдлийн баазын хуулийн 12 (2) дэд хэсэгийг хүчингүй болгож өөрчилсөн. (RT I 1997, 28, 423; 1998, 36/37, 552; 1999, 10, 155; 2000, 50, 317; 57, 373; 92, 597; 2001, 7, 17; 17, 77; 2002, 61, 375; 63, 387)

44. Олон нийтийн мэдээллийн хуулийн нэмэлт өөрчлөлт

Олон нийтийн мэдээллийн хуулинд (RT I 2000, 92, 597; 2002, 61, 375; 63, 387) дараах нэмэлт өөрчлөлт орсон;

- 1) 14 (2) болон (4) дэд заалтуудыг өөрчилж дараах байдлаар томьёолсон.
 - » (2) Хэрэв хувь хүн өөрт нь болон 3 дагч этгээдэд хамаарах хувийн нууц болон эмзэг өгөгдөлтэй холбоотой мэдээ мэдээллийг шаардвал мэдээлэл эзэмшигч мэдээлэл шаардаж байгаа хүнийг таньж тогтооно.
 - » (4) Улсын болон орон нутгийн албан тушаалтан эсвэл албан хаагч албан үүргээ хэрэгжүүлэхийн тулд мэдээ мэдээлэл шаардвал, эсвэл хувь хүн 3 дагч этгээдэд хамаарах хувийн өгөгдөл мэдээлэл шаардвал, тухайн хүн мэдээлэл эзэмшигчид мэдээлэлд нэвтрэх зорилго болон үндэслэлээ гаргаж өгнө.
- 2) 23 (3) дэд хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хүчингүй болгосон.
- 3) 35 (1) дэд хэсэгт 10) болон 11) зүйл ангиуд нэмэгдэж дараах байдлаар томьёолсон:
 - » 10) хувийн нууц болон эмзэг өгөгдөл агуулсан мэдээ мэдээлэл
 - » 11) Өгөгдлийн субъектийн хувийн амьдарлын халдашгүй байдлыг илт алдагдуулахаар хувийн өгөгдөл агуулсан мэдээ мэдээлэл
- 4) 36 (1) б) дахь заалт дараах байдлаар өөрчлөгдсөн:
 - » б) Хувийн нууц болон эмзэг өгөгдөл мэдээллийг оруулахгүйгээр улсын болон орон нутгийн албан тушаалтны нэр хүндийг хохироох, биет хүний эсвэл олон нийтийн үүрэг

даалгаварыг хэрэгжүүлэх хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр хүндийг хохироох мэдээ мэдээлэл

5) 37 дугаар хэсгийг хүчингүй болгосон.;

12)

45. Өмнөх хуульд нийцсэн хувийн эмзэг өгөгдөл мэдээлэллийн бүртгэл

Хувийн өгөгдлийг хамгаалах хуульд (RT I 1996, 48, 944; 1998, 59, 941; 111, 1833; 2000, 50, 317; 92, 597; 104, 685; 2001, 50, 283; 2002, 61, 375; 63, 387) нийцсэн хувийн эмзэг өгөгдөл мэдээллийн боловсруулалтын бүртгэлийг энэ хуулийн хүчин төгөлдөр байдал өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн дотор хүчинтэй гэж үзнэ.

46. Энэ хуулийн хүчин төгөлдөр байдал өөрчлөгдөхөөс өмнө хувийн өгөгдөл боловсруулах тохиролцоог хангасан зөвшилцөл

(1) Энэ хуулийн хүчин төгөлдөр байдал өөрчлөгдөхөөс өмнө хувийн өгөгдөл боловсруулах тохиролцоог хангасан тухайн үеийн хуулинд нийцсэн зөвшилцөлийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

(2) Ерөнхий болон зөвшөөрөл бүхий боловсруулагч өгөгдлийн субъектийн шаардсанаар өгөгдлийн субъектийн хувийн өгөгдлийн устгал болон өгөгдлийн боловсруулалтын цуцлалт, засвар сайжруулалт, хаалт болон ажлын 10 хоногийн дотор хувийн өгөгдөлд нэвтрэх нөхцөлүүдийг бүртгэнэ.

47. Хүчингүй болсон хувийн өгөгдлийг хамгаалах өмнөх хууль

Хувийн өгөгдөл хамгаалах хуулийг (RT I 1996, 48, 944; 1998, 59, 941; 111, 1833; 2000, 50, 317; 92, 597; 104, 685; 2001, 50, 283; 2002, 61, 375; 63, 387) хүчингүй болгосон.

48. Хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэлийн танилцуулга

Хувийн өгөгдөл боловсруулагчийн бүртгэлийг 2004 оны 07 сарын 01 нд танилцуулна. Бүртгэлийн танилцуулга хүртэл энэ хуулийн 25 (1) дэд хэсэгт заасан хүсэлтүүдийг Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад цаасан дээр оруулна. 2004.07.01- ээс өмнө хувийн өгөгдөлийн боловсруулалт үүсгэсэн ерөнхий боловсруулагч 2004.10.31 гэхэд тэмдэглэл хийлгэх үүргээ биелүүлж Өгөгдөл Хамгаалах Хяналтын Байгууллагад тэмдэглүүлнэ.

49. Entry into force of the Act – Хуулийн хүчин төгөлдөр байдал

(1) Энэ хууль 2003.10.01-ээм хүчин төгөлдөр үйлчилнэ.

(2) Энэ хуулийн 4 болон 26 (4) дэд хэсэг 2004.07.01-ээс хүчин төгөлдөр үйлчилнэ.

(3) Энэ хуулийн 28 (2) дэд хэсэг хүчингүй болсон, мөн 28 (3) болон (5) дэд хэсэг Эстони улс Европын холбоонд нэгдсэнээр хүчин төгөлдөр үйлчилнэ.